

МУИС-ийн Оюутны албанаас

Оюутан суралцагчдыг хөдөлмөрийн зах зээлд бэлдэх, чадавхижуулах” зорилготой Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд явуулсан сургалт, зөвлөх үйлчилгээнд хамрагдсан оюутнуудын сэтгэл ханамжийн санал асуулгын дүн

МУИС-ИЙН ОЮУТНЫ АЛБА
2015 ОНЫ 12-Р ДУГААР САР

МУИС-ийн Оюутны алба оюутнуудад зориулан, “Оюутан суралцагчдыг хөдөлмөрийн зах зээлд бэлдэх, чадавхижуулах” зорилготой сургалт зохион байгуулав.

Сургалтыг үндсэн 4 сэдвээр зохион байгуулсан бөгөөд **”Ажил хайх тактик”**, **”CV хэрхэн бичих вэ?”**, **”Ажлын ярилцлагад орох зөвлөмж”**, **”Дадлага яаж хийдэг вэ, интерншип гэж юу вэ”** гэсэн сэдвүүдээр БС-ийн менежментийн тэнхимийн дэд профессор З.Алтанчимэг, ахлах багш Б.Сарантуяа, ахлах багш Б.Шүрэнцэцэг, Социологи нийгмийн ажлын тэнхимийн ахлах багш Ч.Тамир нар сургалт, зөвлөгөөг явуулав.


2015 оны 11 сарын 27-ноос 12 сарын 4 хүртэл үргэлжилсэн энэхүү сургалтанд бүрэлдэхүүн сургуулын 300 гаруй оюутнууд хамрагдлаа.

МУИС-ийн Оюутны алба

2015 он


Сургалтанд оролцсон оюутнуудыг бүрэлдэхүүн сурууль болон түвшингээр нь ялган харвал

БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ



- Бизнесийн сургууль
- ОУХНУС
- Хууль зүйн сургууль
- ШУС
- ХШУИС


ТҮВШИН



1-р түвшин 2-р түвшин 3-р түвшин 4-р түвшин 5-р түвшин


Нас болон хүйсээр ялган харвал

Нас болон хүйс




Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажлын хүрээнд хийгдсэн сургалтыг хангалттай мэдээлэлтэй, үр өгөөжөө өгсөн сургалт болсон эсэх талаар оюутнууд хариулахдаа

Хангалттай мэдээлэлтэй болсон эсэх



■ Хангалттай ■ Хангалтгүй


Үр өгөөжөө өгсөн сургалт болсон эсэх




■ Тийм ■ Үгүй

Сургалтанд суусан оюутнуудын доорх сэдвүүдэд ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

ОЮУТНУУДЫН ӨГСӨН ҮНЭЛГЭЭ



Оюутны албаны зүгээс цаашид оюутнуудад зориулж ямар төрлийн сургалт, зөвөлгөө, мэдээлэл явуулах хэрэгтэй вэ? гэдэг асуултанд оюутнууд:



Товч дүгнэлт

МУИС-ийн Оюутны алба оюутнуудад зориулан, “Оюутан суралцагчдыг хөдөлмөрийн зах зээлд бэлдэх, чадавхижуулах” зорилготой уг сургалтанд бүрэлдэхүүн сургуулийн 300 гаруй оюутан хамрагдсанаас 180 оюутан судалгаанд оролцож сургалтын талаар өөрийн санал бодлоо хуваалцлаа.

Сургалтанд хамрагдсан оюутнууд дадлага болон интерншипийн талаар ойлголттой болж, төгсөөд ямар арга зам, стратеги ашиглаж хүссэн ажилдаа орох талаар тодорхой мэдлэгтэй боллоо.

Цаашид энэхүү сургалтаа үргэлжлүүлэн зохион байгуулж, сургалтын сэдвийг өргөжүүлж илүү олон оюутнуудыг хамруулах хэрэгтэй гэж судалгаанд хамрагдсан оюутнууд өөрсдийн саналаа тусгажээ.

Уг сургалтын тухай судалгаанд оролцсон оюутнууд дараах саналуудыг дурдсан байна.

- Ажлын ярилцланд орж байгаа жишээг бичлэг хэлбэрээр хүргэх
- Ажлын байран дээрх бусдын нөлөөллын талаар дэлгэрэнгүй ярих
- Сургалтын явцад практик дадлага хийх
- Нарийвчилсан зөвөлгөө өгөх буюу уг сургалтыг сэдэв тус бүрээр задалж тус тусад бүтэн 1 цагийн лекц болгож хийх
- Уг сургалтаа тогтмол явуулах мөн хэлэлцүүлэг маягаар дундаа завсарлага авч сэдэв тус бүрээр ярилцах гэх мэт саналуудыг тусгажээ.

Сургалтанд оролцсон оюутнууд дараах сургалтуудыг санал болголоо:

- Бизнес эхлүүлэх санаагаа хаанаас олж авах вэ?
- Хувь хүнийг хэрхэн хөгжүүлэх талаар
- Хэрхэн өөртөө итгэлтэйгээр ярилцлаганд орох вэ
- Цаг төлөвлөлт буюу цагаа үр дүнтэй өнгөрөөх аргууд
- Цалин, мөнгөө хэрхэн үр дүнтэй зарцуулах
- Компьютерийн хэрэглээний программын сургалт зохион байгуулах
- Төгсөөд ажилд хараахан ороогүй байгаа төгсөгчдөд зориулсан ажил, хөдөлмөр эрхлэх талаар сургалт зохион байгуулах зэрэг саналууд дэвшүүлжээ.